



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид
хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн
этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, 63 дугаар зүйлийн 63.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси” ХХН /Б.Нямцэрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН